



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/156

Мандагзовь

“Хайя Тек” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/76 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Дундговь аймаг Сайнцагаан сум 3-р цэцэрлэгийн барилгын засварын ажил”-ын гүйцэтгэгчээр шалгарсан “Хайя Тек” ХХК-тай 530,929,159 (таван зуун гучин сая есөн зуун хорин есөн мянга нэг зуун тавин ес) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2.Батлагдсан зураг төсвийн дагуу 3-р цэцэрлэгийн барилгын засварын ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Хайя Тек” ХХК-ний захирал (А.Батхуяг)-д үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Боловсрол, соёл урлагийн газрын дарга (Ц.Уранбямба), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



488210078